

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	2023 оны	2023 оны гүйцэтгэл	Оноо	Хувь
			2020 он	зорилтот түвшин			
Эдийн засгийн үзүүлэлт							
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая.т	802,814.7 /2019 он/	842814,7	2023 оны ДНБ-ны урьдчилсан гүйцэтгэл 2024 оны 6 сард гарах тул одоо урьдчилж нарийн тооцох боломжгүй.		
2	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая.т	7398.7	7753.7			
3	Төсвийн орлого	Сая.т	103587.3	104032.0	103,095.5	4.95	99.1
4	Төсвийн зардал	Сая.т	92217.0	104032.0	101,578.2	5	100
5	Төсвийн тэнцэл		11370.3	0	1517.3	5	100
6	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	86	89	75	4.2	84.3
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	Хувь	60.0	68.0	80.4	5	100
8	Ажилгүйдлийн түвшин	Хувь	5.2	4.5	6.3	5	100
9	Ажиллах хүчний оролцооны хувь	Хувь	46.1	51.0	48.65	Үндэсний Статистикийн хорооноос ажиллах хүчний оролцооны хувийг 2023 оны гүйцэтгэлийг 2024 оны 2 дугаар улиралд гаргадаг тул боломжгүй байна.	
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан	Хувь	88.1	91	89.7	5	98.5

	иргэдийн нийт хүн амд эзлэх хувь						
11	Эдийн засгийн идэвхитэй хүн ам /ажиллах хүч/-ийн нийгмийн даатгалд эзлэх хувь	Хувь	46.4	53.4	2023 оны хүн амын тоо эцэслэж гаргаагүй тул гаргах боломжгүй байна.		
12	Шинээр бий болсон ажлын байрны тоо	Тоо	1050	1000	1281	5	100
13	Хэрэглээний үнийн индекс	Индекс	3.6	3.0	8,3	5	100
14	Малын тоо	Мянган толгой	1682489	1337489	1 769 402	5	100
15	Хураан авсан үр тариа	Мянган тонн	181.0	185.0	196,8	5	100
16	Хураан авсан малын тэжээл бусад	Мянган тонн	23.2	23.0	24,5	5	100
17	Хураан авсан хүнсний ногоо	Мянган тонн	35.1	37.0	86,3	5	100
18	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	Тоо	-	1500	221 700	5	100
19	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын тоо	Тоо	2442	2550	3505	5	100
20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан нийт өрхөд эзлэх хувь	Хувь	25.6	40	32,2	4.0	80.5
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	84.8	90	95,3	5	100
Нийгмийн хөгжлийн үзүүлэлт							
22	Хүн амын дундаж наслалт	Тоо	72.25	72.28	Үндэсний Статистикийн хорооноос 2024 оны 03 дугаар сарын 14-өөс хойш хүн амын дундаж наслалт гарах тул гаргах боломжгүй байна.		

23	Хүний хөгжлийн индекс	Индекс	0.696	0.699	Үндэсний Статистикийн хорооноос Хүний хөгжлийн индекс 2023 оны гүйцэтгэлийг 2024 оны 2 дугаар улиралд гаргадаг тул одоогоор гаргах боломжгүй байна.		
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	Индекс	0.29	0.32	0.313	5	100
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	557	557	726	5	100
26	Иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин	Хувь	52.1	58.2	59.1	5	100
27	PM 2,5 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м3	-	-	21	5	100
28	PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м3	92	74	28	5	100
29	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	Хувь	43.6	43.666	43,6	5	100
30	Дахин боловсруулан хог хаягдлын эзлэх хувь	Хувь	-	30	18,2	3	60.6
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	Хувь	-	40	31,7	4	80
32	100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	Промиль	0	0	0	Үндэсний Статистикийн хорооноос 2024 оны 2 дугаар улиралд амьд төрөлтөд ногдох эхийн	

						эндэгдлийн түвшин гарах тул гаргах боломжгүй байна.	
33	1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промиль	6.1	5.6	13	0	0
34	10 000 хүн амд Вируст гепатитын өвчлөл	Тоо	2	1	0	5	100
35	Тухайн жилийн товлोलт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	99.0	99.2	99.4	5	100
36	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	97.1	99.4	66.9	3.4	67.3
37	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	85.2	91	96.5	5	100
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн үе	Хувь	54.1	56.2	69.5	5	100
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	82.8	83.2	93.4	5	100
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	87.4	87.7	92	5	100
41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	27.0	25.5	30.1	4.7	94.4
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	29.7	28.5	28.6	5	100

43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	Тоо	498.0	499.5	497	5	99.5
44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	Тоо	0	0	0	-	-
45	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	54	184		5	100
Хэрэгжилт						4.7	93.6

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Үүнээс онцлог үзүүлэлтүүдийг дурдвал:

1.6. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь

“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”, “Хоршоо хөгжүүлэн сан”-гийн хөнгөлөлттэй зээлд Ерөө, Хүдэр, Мандал, Жавхлант, Баянгол, Зүүнбүрэн, Цагааннуур, Хушаат, Сайхан, Орхон, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумдын 84 аж ахуйн нэгж, иргэнд 2 тэрбум 506 сая төгрөг зээлийг үйлдвэр, үйлчилгээ байгуулах чиглэлээр олгож, шинээр 203 ажлын байр бий болж, зээлийн эргэн төлөлт 75 хувьтай, сүү боловсруулах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, авто засвар, авто угаалга, үсчин, гоо сайхан, хувцас захиалга засвар вакум цонх, хаалганы үйлдвэр, үйлчилгээний газрууд байгуулахад нь дэмжлэг үзүүлсэн.



1.12. Шинээр бий болсон ажлын байр



Энэ онд шинээр Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй, загас ан агнуурын чиглэлээр 273, боловсруулах үйлдвэрт 170, уул уурхай, олборлох үйлдвэрт 141, худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээний чиглэлээр 114, урлаг, үзвэр үйлчилгээний чиглэлээр 76, барилгын салбарт 64, боловсролын салбарт 49, зочид буудал, зоогийн газарт 38, төрийн удирдлага, батлан хамгаалахын чиглэлээр 22 иргэн, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр 18, тээвэр, холбооны чиглэлээр 11, санхүүгийн чиглэлээр 6, цахилгаан, дулаан, усан хангамжийн салбарт 2 иргэн нийт 1288 ажлын байр, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”, “Хоршоо хөгжүүлэн сан”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-ийн хөнгөлөлттэй зээлд 84 аж ахуйн нэгж, иргэдэд 2 тэрбум 506 сая төгрөгийн зээлийг олгож, шинээр 203 ажлын байр бий болгон өмнөх оныхоос 4,1 хувиар нэмэгдүүлсэн.

1.13. Хэрэглээний үнийн индекс

Аймгийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурахад бусад бараа үйлчилгээ 16.6 хувь, даатгал санхүүгийн үйлчилгээ 15.4 хувь, хүнсний бараа, согтууруулах бус ундаа 13.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 12.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 9.5 хувь, хувцас, бөс бараа, гутал 8.4 хувь, согтууруулах ундаа, ус,



ундаа, тамхи, мансууруулах бодис 5,2 хувь, тээвэр 4.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 1.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 0.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 0.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

1.14. Малын тоон өсөлт

2023 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээнд 5522 малчин өрх, 5030 мал бүхий өрх, 72 аж ахуйн нэгжид 1769402 толгой мал тоологдож малын тоо өнгөрсөн оноос 142.9 мянган толгой буюу 7.5 хувиар буурлаа. Малын тоо толгойг өсгөхгүй, ашиг шимтэй малыг үржүүлэн эрчимжсэн мал аж ахуйг дэмжин ажиллаж байна.



Малын тоог төрлөөр нь авч үзвэл тэмээ 591, адуу 140336, үхэр 303296, хонь 787932, ямаа 537247 тус тус тоологдсон нь өнгөрсөн оноос тэмээ 38, адуу 11113, үхэр 2838 толгойгоор өссөн, хонь 69510, ямаа 89417 толгойгоор тус тус буурсан байна.

1.15. Хураан авсан үр тариа

Энэ онд 131.6 мянган га талбайгаас 196,8 мянган тн буюу нэгж га талбайгаас 14,8 цн үр тариа, хүнсний ногоо тариалснаас хойшхи хугацаанд хамгийн их талбайгаас хамгийн их ургац буюу 4,9 мянган га талбайгаас 86,3 мянган тонн ургацыг тус тус хураан авсан.



1.16. Хураан авсан малын тэжээл

Аймгийн хэмжээнд 17,3 мянган га талбайгаас 24,4 мянган тн тэжээлийг хураан авсан. Сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд 1020 тн өвс, 680 тн тэжээл бэлтгэхээс 825 тн өвс, 460 тн тэжээл бэлтгэсэн нь 65,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

1.17. Хураан авсан хүнсний ногоо

Төмс 2,7 мянган га талбайгаас 33,7 мянган тн, хүнсний ногоо 4,9 мянган га талбайгаас 86,3 мянган тн хураан авч, төмсний тариалалт 17,1 хувиар, хүнсний ногооны тариалалт 22,9 хувиар тус тус нэмэгдсэн.



1.18. Хүлээн авах гадаад жуулчин



Алтанбулаг, Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 613.3 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оныхоос 339.2 мянган хүнээр өсөж, нийт зорчигчдын 401.6 мянга буюу 65,5 хувь нь Монгол иргэд, 211.8 мянга буюу 34.5 хувь нь гадаад иргэд хилээр нэвтэрч, өмнөх оныхоос Монгол иргэдийн тоо 2,3 дахин, гадаад иргэдийн тоо 2,2 дахин өссөн.

1.19. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага



Бизнес регистрийн санд 7174 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 3505 буюу 48.8 хувь нь үйл ажиллагаа явуулж, Сүхбаатар, Мандал, Сайхан, Ерөө суманд 2187 буюу 62.4 хувь, Хүдэр, Баянгол сумдад 741 буюу 21.1 хувь, Цагааннуур,

Алтанбулаг, Шаамар сумдад 577 буюу 16.5 хувь, бусад сумдад үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрээр нь авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж 411, Монгол Улсын иргэний өмчийн 3057, гадаад улсын иргэнтэй хамтарсан 11, гадаад улсын иргэний өмчийн 26 аж ахуйн нэгж байна.

1.20. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан нийт өрхөд эзлэх хувь



Аймгийн нийт өрхийн 72.4 хувь нь байшинд, 25.9 хувь нь Монгол гэрт амьдарч байгаа нь өмнөх оныхоос байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь 0.7 пунктээр буурчээ. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 13.8 хувийг эзэлж, 2022 оныхоос 0.8 хувиар буурчээ.

1.21. Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь

Халаалтын төвлөрсөн системд холбогдсон өрх 18.4 хувь, цахилгааны төвлөрсөн системд өрх 83.4 хувь, төвлөрсөн усан хангамжинд 17.3 хувь, бохир ус зайлуулалтын төвлөрсөн системд өрх 15.7 хувь тус тус холбогдсон байна.



1.25. Бүртгэгдсэн гэмт хэрэг



Аймгийн хэмжээнд 2023 онд 611 холбогдогчтой 3.022.500.000 төгрөгийн хохиролтой 726 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 49 хэргээр буюу 6.3 хувиар буурсан.

1.26. Иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин



Гэмт хэрэг, зөрчлийн улмаас иргэн, аж ахуй нэгжид 3.022.500.000 төгрөгийн хохирол учирсан. Тус хохирлын 1.787.200.000 төгрөг буюу 59.1 хувийг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлж ажилласан.

1.27. PM 2,5 тоосонцорын жилийн дундаж агууламж

Сүхбаатар сумын агаарын чанарын 1 дүгээр харуул, Мандал сумын Зүүнхараа агаарын чанарын 2 дугаар харуулын шинжилгээгээр 2023 онд агаарын чанарыг автомат багажаар тодорхойлоход 21 М кг/м³ байгаа нь агаарын чанарын ангилалаар хэвийн буюу стандартын шаардлага хангаж байна.

1.28. PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж

Агаарын чанарын шинжилгээгээр энэ онд PM10 том ширхэглэг тоосонцорын жилийн дундаж агууламж 28 М кг/м³ байгаа нь өмнөх оноос 16 М кг/м³ буурч агаарын чанар бага бохирдолтойгоор хэвийн буюу агаарын чанарын стандартын шаардлага хангасан байна.

1.29. Ойгоор бүрхэгдсэн талбай

Аймгийн хэмжээнд ойн сангийн талбай 1931.2 мянган га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 1441.0 мянган га, байгалийн ой 1397.4 мянган га, ойгоор бүрхэгдээгүй ойн талбай 406.6 мянган га буюу 43,6 хувийг эзэлж байна.



1.30. Дахин боловсруулах хог хаягдал



Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг “Хэт жолоо” ХХК нь 4 иргэнийг улирлын чанартай ажлын байраар ханган Хонгор морьтын хог хаягдлын нэгдсэн цэгээс хуванцар хаягдлыг ялган цуглуулж преслэн Дархан-Уул аймгийн “Сан Оргиу” ХХК-д нэг удаагийн тээвэрлэлтээр 3 тн хуванцар, малсо, канистр 2 тн 800 кг, өнгөгүй бүх төрлийн гялгар уут 6 тн 300 кг, ундаа, пивоны лааз 4 тн 280 кг нийт 16,38 тн-ыг дахивар хог хаягдлыг дахин боловсруулж, дахин ашиглах боломжтой архины шил 250,000 ширхэг буюу 150 тонн орчимыг тушааж, 32,4 сая төгрөгийн борлуулалт хийсэн.



Орон нутгийн хөгжлийн сангийн 34,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сант суманд “Хогийн цэгийн хашаажуулалт, тохижилтын ажил”-ыг хийж, Баруунбүрэн, Сант, Орхон сумдууд төвлөрсөн хог хаягдлын 6.7 га талбайг түрж хумьж, цэгцлэн, булшилсан.

1.31.Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдал



Сүхбаатар сумын Хонгор морьтын 1-р багт “Аюултай хог хаягдал түр хадгалах агуулах” барих ажлыг “Цомбон тоосго” ХХК хийж ашиглалтад оруулж, энэ онд 5542.4 тн аюултай хог хаягдал тоологдож, аюултай хог хаягдал үүсгэгчийг тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Түмэн эгшиг” ХХК, “Цэцүүх” ХХК-иар устгуулсан.